



Уран үгийн их мастерууд онгорсон бямба, ням гаригт Дархан-Уул аймагт чуулж "Болор цом 28"-ийн эзэн найрагчийг тодрууллаа. 360-аад найрагчдын бүтээлээс 58 найрагчийн бүтээл хоёрдугаар шатанд уншигдсан бол гуравдугаар шатанд 20 найрагч тайзнаа гарах эрхтэй болсон юм.

. Наадмыг Ардын уран зохиолч, Торийн шагналт, яруу найргийн их тэнгэрүүд гэгддэг Б.Лхагвасүрэн, Ш.Сүрэнжав, Ш.Дулмаа, Т.Галсан, Д.Цоодол нар улам ч гоёмсог болгож байлаа. Наадмын гуравдугаар шатанд ямар 10 найрагч шүлгээ дахин сонсох нь хвлээлт болов. Ардын уран зохиолч, торийн шагналт Т.Галсангаар ахлуулсан шүүгчдийн дүнг найрагчид, үзэгчидгүй гэгэлзэн хвлээв. Энэ зуур наадмыг хотолсон яруу найрагч, СГЗ Ш.Гүрбазар нэгэн хүнийг тайзнаа зарласан нь Ардын уран зохиолч, Торийн шагналт Б.Лхагвасүрэн байлаа. Их найрагч тэрбээр, "Урд би энэ тайзан дээр зарлуулж гардаг яруу найрагч байлаа. Харин одоо завсарлагааны яруу найрагч болж дээ" хэмээсэн нь үзэгчдэд инээд, нулимс хоёрыг бэлэглэв. Онжүүлийн их найрагч цаанаа л гуниглуу басхүү бардамханаар "Монгол байна" шүлгээ уншаад буусан. Ийм их гуниг байдгийг үзэгчид мэдэрч алгаа хоростол таших нь танхимд яруу найргийн халуухан үдэш үргэлжилж байгааг сануулах шиг болсон. Шүүгчид дүнгээ гаргажээ. Цомын толоо А.Эрдэнэ-Очир, Л.Монхбат, Н.Гантулга, М.Уянсүх, Ц.Хулан нар тайзнаа дахин гарах нь тодорхой боллоо.

Холын замд улдаж, эцэж туйлдсан хвлэг морь шиг хүн чулуу минь

Хорвоогийн бүхий л онгийг оортоо шингээж, гоо үзэсгэлэнгээ гайхуулах бүсгүй шиг хүн чулуу минь

Дотоод ахуйдаа уусч мянган жил дүрээ харуулаагүй нууцлаг ертөнц хүн чулуу минь
Доголон нулимсаа хэнээс ч нуулгүй арчиж талын салхинд зүлгэгдсэн уулсаа түших хүн чулуу минь... хэмээсэн Н.Гантулгын шүлгээр сүүлийн шат эхэлсэн. Ингээд найрагчид шүлгээ хэлж дуусахад наадмын шүүгчид тайзнаа цомын эзний алдрыг дуудах моч танхимыг чимээгүй болгов. Ерөнхий шүүгч Т.Галсан, нэгэн зүйл онцолж хэлсэн нь "Лхагвасүрэн чиг бол заллагын яруу найрагч, чиг бол замбуулингийн яруу найрагч, чиг бол заяаны яруу найрагч юм" хэмээсэн нь үзэгчдийн болор цомын эзэн найрагчийг хвлээх хвлээлтийг эвдсэн юм. Ингээд "Дархан 50-Болор цом 28" наадам Ц.Хулан найрагчийн нэрийг зарлаж цомоо гардууллаа. Наадамд М.Уянсүх, Л.Монхбат, Н.Гантулга,

А.Эрдэнэ-Очир нар удаалж дараа жилийн наадмаар дахин уулзахын ероол талбив.